



**САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ**

Эгийн голын усан цахилгаан станц ТӨХХК -ийн 2023 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын хураангуй тайлан

**Аудитын код:** СНАГ-2024/3/НА-СТА-ТӨА

<p>Цахим хуудас: <a href="http://www.audit.mn">www.audit.mn</a> Улаанбаатар хот 2024 он</p>	<p>Санхүү-нийцлийн аудитын газрын захирал, тэргүүлэх аудитор: Ц.Наранчимэг Утас: 51-261663 Цахим хаяг: naranchimegts@audit.gov.mn Аудитын менежер: Б.Долгорсүрэн Утас: 51-261885 Цахим хаяг: dolgorsuren@audit.gov.mn Ахлах аудитор: П.Амарсанаа Утас: 51-261740 Цахим хаяг: amarsanaap@audit.gov.mn Нийслэл-Аудит ХХК-ийн захирал: Т.Сугарсүрэн Утас: 70110095 Цахим хаяг: info@niislelaudit.mn</p>
---	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



## ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг  
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр  
Утас:26-04-37, Факс:51-26-42-30  
E-mail: info@audit.gov.mn

2024.03.15 № 071714  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

ЭГИЙН ГОЛЫН УСАН ЦАХИЛГААН  
СТАНЦ ТӨХХК-ИЙН ГҮЙЦЭТГЭХ  
ЗАХИРАЛ М. БАТТУЛГА ТАНАА

### Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, 8.4, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Эгийн голын усан цахилгаан станц ТӨХХК-ийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй тайлан, өмчийн өөрчлөлтийн тайлан, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгуудад аудит хийлээ

Эгийн голын усан цахилгаан станц ТӨХХК-ийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

### Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

### Асуудлыг онцолсон хэсэг

Эгийн голын усан цахилгаан станц ТӨХХК нь Монгол Улсын эрчим хүчний нэгдсэн системд үр ашигтай тохируулга хийж, оргил ачааллыг давж гарах чадвар бүхий эх үүсвэрийг бий болгох зорилго бүхий эрчим хүчний нэн чухал төслийг хэрэгжүүлэх үүрэг бүхий аж ахуйн нэгж бөгөөд ОХУ-ын талаас өмнөх жилүүдэд тус төслийг дэмжихгүй гэсэн байр суурьтай байсан бол 2023 онд төслийн үйл ажиллагаатай холбоотой хоёр улсын төлөөлөгчдийг оролцуулсан хилийн усны болон бусад хэлэлцээр хамтын ажиллагааны үр дүнд хил дамнасан бүс нутгийн байгаль орчны үнэлгээг хамтран хийж, төслийг хэрэгжүүлэх үйл ажиллагаанд ОХУ хамтран оролцох сонирхлоо илэрхийлсэн нь цаашдын үйл ажиллагаанд чухал түлхэц болсон байна.

Сэлэнгэ мөрөн, Байгал нуурын биологийн олон янз байдалд Эгийн голын усан цахилгаан станц төслийн үзүүлэх нөлөөллийг тодорхойлох, нөлөөллийг хамгийн бага байлгах зорилгоор хэд хэдэн төрлийн судалгааг хийсэн нь өмнөх онуудад хийсэн тойм судалгаатай харьцуулахад илүү нарийвчилсан үр дүнтэй болсон байна.

Өмнөх онд хийсэн Эгийн голын усан цахилгаан станц ТӨХХК-ийн ТЭЗҮ, төслийн санхүү, эдийн засгийн тооцоог урьдчилсан байдлаар шинэчлэн гаргаж, Хөгжлийн банкны хуримтлагдсан өр төлбөрийг төлөх эх үүсвэрийг улсын төсөвт үе шаттайгаар тусгаж шийдвэрлүүлэх талаар Засгийн газрын тогтоолын төслийг боловсруулан хүргүүлсэн бөгөөд Засгийн газрын 2024 оны 1 дүгээр сарын 10-ны өдрийн хуралдаанаар дэмжин тогтоолыг баталсан байна.

### **Аудитын гол асуудал**

Эгийн голын усан цахилгаан станц ТӨХХК-ийн 2023 оны санхүүгийн тайлан, тодруулгад хийсэн аудит нь Төрийн аудитын байгууллагаас 2023-2024 онд гүйцэтгэх аудитад баримтлах ерөнхий чиглэл, мөн санхүү, төсөв, нийтийн өмчтэй холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн актын хэрэгжилт, тэдгээрийн нийцэл зэрэг асуудлуудыг тусгайлан авч үзэж, үр дүнг тайлагнахад чиглэгдсэн.

### **Бусад асуудлын хэсэг**

Тус байгууллага тайлант оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 6 зорилтын хүрээнд 35 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж, гүйцэтгэлээр 88.0 хувийн гүйцэтгэлтэй гэж тайлагнасан байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

### **Удирдлага болон Засаглах эрх бүхий этгээдийн санхүүгийн тайланд хүлээх үүрэг, хариуцлага**

Удирдлага нь санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

### **Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

САНХҮҮ-НИЙЦЛИЙН АУДИТЫН ГАЗРЫН  
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Ц.НАРАНЧИМЭГ

## 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдөр

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	Үзүүлэлт	2023 оны 01-р сарын 01	2023 оны 12-р сарын 31
1	<b>ХӨРӨНГӨ</b>		
1.1	<b>Эргэлтийн хөрөнгө</b>		
1.1.1	Мөнгөн түүнтэй адилтгах хөрөнгө	1,043,352,732.97	93,426,627.46
1.1.2	Дансны авлага		
1.1.3	Татвар, НДШ-ийн авлага		
1.1.6	Бараа материал	12,714,428.48	11,023,272.97
1.1.7	Урьдчилж төлсөн зардал тооцоо	1,324,306.63	6,618,731.82
1.1.	Бусад авлага		
1.1.11	<b>Эргэлтийн хөрөнгийн дүн</b>	<b>1,057,391,468.08</b>	<b>111,068,632.25</b>
1.2	<b>Эргэлтийн бус хөрөнгө</b>		
1.2.1	Үндсэн хөрөнгө	16,666,116,274.74	16,438,335,118.70
1.2.2	Биет бус хөрөнгө	18,635,520,000.00	18,641,637,652.51
1.2.10	<b>Эргэлтийн бус хөрөнгийн дүн</b>	<b>35,301,636,274.74</b>	<b>35,079,972,771.21</b>
1.3	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>36,359,027,742.82</b>	<b>35,191,041,403.46</b>
2	<b>ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ</b>		
2.1.1	<b>Богино хугацаат өр төлбөр</b>	99,095,726.51	100,303,192.16
2.1.1.1	Дансны өглөг	93,540,320.12	92,718,000.00
2.1.1.2	Цалингийн өглөг		237,065.12
2.1.1.3	Татварын өр	4,323,417.51	6,116,138.04
2.1.1.4	НДШ-ийн өглөг		
2.1.1.10	Бусад богино хугацаат өр төлбөр	1,231,989.00	1,231,989.00
2.1.1.13	<b>Богино хугацаат өр төлбөрийн дүн</b>	<b>90,095,726.51</b>	<b>100,303,192.16</b>
2.1.2.4	Бусад урт хугацаат өр төлбөр	56,310,944,820.08	59,986,142,785.14
2.2	<b>Өр төлбөрийн нийт дүн</b>	<b>56,410,040,546.59</b>	<b>60,086,445,977.30</b>
2.3	Эздийн өмч		
2.3.1	Төрийн өмч	20,000.00	20,000.00
2.3.6	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл		
2.3.8	Эздийн өмчийн бусад хэсэг	18,635,520,000.00	18,635,520,000.00
2.3.9	Хуримтлагдсан ашиг	(38,686,552,803.77)	(43,530,944,573.84)
2.3.11	<b>Эздийн өмчийн дүн</b>	<b>(20,051,012,803.77)</b>	<b>(24,895,404,573.84)</b>
2.4	<b>ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ</b>	<b>36,359,027,742.82</b>	<b>35,191,041,403.46</b>

## 2.2 Аудит хийсэн орлогын дэлгэрэнгүй тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдөр

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	Үзүүлэлт	2023 оны 01-р сарын 01	2023 оны 12-р сарын 31
1	<b>Борлуулалтын орлого ( цэвэр )</b>		
2	Борлуулалтын өртөг		
3	<b>Нийт ашиг ( алдагдал )</b>		
4	Түрээсийн орлого	3,250,440.00	3,250,440.00
5	Хүүгийн орлого		1,351,791.80
6	Бусад орлого	695,407,800.00	949,944,392.00
7	Борлуулалт, маркетингийн зардал		
8	Ерөнхий ба удирдлагын зардал	229,090,176.15	530,003,095.71
9	Санхүүгийн зардал	2,568,603,429.20	4,293,511,883.43
10	Бусад зардал		4,870,600.00
11	Гадаад валютын ханшийн зөрүүтэй олз (гарз)	(9,008,685,505.72)	635,080,251.44
12	Үндсэн хөрөнгө данснаас хассаны олз (гарз)		
13	Бусад ашиг (алдагдал)		<b>(167,737,967.48)</b>
14	<b>Татварын өмнөх ашиг ( алдагдал )</b>	<b>(11,107,720,871.07)</b>	<b>(3,406,496,671.38)</b>
15	Орлогын татварын зардал		
16	<b>Татварын дараах ашиг ( алдагдал )</b>	<b>(11,107,720,871.07)</b>	<b>(3,406,496,671.38)</b>
17	<b>Тайлант үеийн цэвэр ашиг ( алдагдал )</b>	<b>(11,107,720,871.07)</b>	<b>(3,406,496,671.38)</b>
18	<b>Орлогын нийт дүн</b>	<b>(11,107,720,871.07)</b>	<b>(3,406,496,671.38)</b>

## 2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдөр

/төгрөгөөр/

	Үзүүлэлт	Өмч	Эздийн өмчийн бусад хэсэг	Хуримтлагдсан ашиг	Нийт дүн
1	<b>2021 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл</b>	<b>20,000.00</b>	<b>18,635,520,000.00</b>	<b>(27,578,831,932.70)</b>	<b>(8,942,541,932.70)</b>
	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга				
2	Залруулсан үлдэгдэл			(27,578,831,932.70)	(8,942,541,932.70)
3	Тайлант үеийн цэвэр ашиг ( алдагдал )			(11,107,720,871.07)	(11,107,720,871.07)
	Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн				
4	<b>2022 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл</b>	<b>20,000.00</b>	<b>18,635,520,000.00</b>	<b>(38,686,552,803.77)</b>	<b>(20,051,012,803.77)</b>
5	Нягтлан бодох бүртгэлийн өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга			(1,437,895,098.69)	(1,437,895,098.69)
6	Залруулсан үлдэгдэл			(40,124,447,902.46)	(21,488,907,902.46)
7	Тайлант үеийн цэвэр ашиг ( алдагдал )			(3,406,496,671.38)	(3,406,496,671.38)
8	<b>2023 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл</b>	<b>20,000.00</b>	<b>18,635,520,000.00</b>	<b>(43,530,944,573.84)</b>	<b>(24,895,404,573.84)</b>

## 2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдөр

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	Үзүүлэлт	2023 оны 01-р сарын 01	2023 оны 12-р сарын 31
1	<b>Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ</b>		
1.1	Мөнгөн орлогын дүн (+)	698,658,240.00	954,546,623.80
1.1.1	Бараа борлуулсан үйлчилгээ үзүүлсний орлого	695,407,800.00	949,944,392.00
1.1.2	Эрхийн шимтгэл, хураамж, төлбөрийн орлого		
1.1.3	Даатгалын нөхвөрөөс хүлээн авсан мөнгө		
1.1.6	Бусад мөнгөн орлого	3,250,440.00	4,602,231.80
1.2	Мөнгөн зарлагын дүн (-)	240,811,544.02	1,873,244,481.12
1.2.1	Ажиллагчдад төлсөн	126,879,831.41	229,756,451.97
1.2.2	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	38,979,766.95	66,285,995.78
1.2.3	Бараа материал худалдаг авахад төлсөн		102,871,631.84
1.2.4	Ашиглалтын зардалд төлсөн		48,428,917.55
1.2.5	Түлш, шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн	31,643,808.26	29,658,645.95
1.2.7	Татварын байгууллагад төлсөн	10,260,692.89	22,900,298.23
1.2.8	Даатгалын төлбөрт төлсөн	1,918,770.00	
1.2.9	Бусад мөнгөн зарлага	31,128,674.51	1,373,342,539.80
1.3	<b>Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн</b>	<b>457,846,695.98</b>	<b>(918,697,857.32)</b>
2.1	Мөнгөн орлогын дүн (+)	2,442,779.63	1,351,791.80
2.1.6	Бусад олгосон зээл, мөнгөн урьдчилгааны буцаан төлөлт	2,442,779.63	
2.1.7	Хүлээн авсан хүүний орлого		1,351,791.80
2.2	Мөнгөн зарлагын дүн (-)		32,580,039.99
2.2.1	Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн		31,700,039.99
2.2.2	Биет бус хөрөнгө олж эзэмшихэд төлсөн		880,000.00
2.3	<b>Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн</b>	<b>2,442,779.63</b>	<b>(31,228,248.19)</b>
3	<b>Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ</b>		
3.1	Мөнгөн орлогын дүн (+)		
3.1.1	Зээл авсан, өрийн үнэт цаас гаргаснаас хүлээн авсан		
3.1.4	Валютын ханшийн тэгшитгэлийн ашиг		
3.2	Мөнгөн зарлагын дүн (-)		
3.2.5	Валютын ханшийн тэгшитгэлийн алдагдал		
3.3	<b>Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн</b>	<b>(120,286,245.70)</b>	<b>0,00</b>
4	Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	340,003,229.91	(949,926,105.51)
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	703,349,503.06	1,043,352,732.97
6	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	1,043,352,732.97	93,426,627.46

## 2.5 Эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдөр

/сая төгрөгөөр/

№	Үзүүлэлтүүд	Х/н	2022	2023			
				Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
1	<b>Нийт орлого</b>	сая.төг	1,402.0	1,011.5	1,589.6	(57.0)	
	Хүүгийн орлого	сая.төг			1.3	(1.3)	
	Үйл ажиллагааны бус орлого	сая.төг	3.3	3.3	3.3	0	
	Улсын төсвийн санхүүжилт	сая.төг	695.4	1,008.2	949.9	(58.3)	
	Бусад /Гадаад валютын ханшийн зөрүүний олз/	сая.төг			635.1	(645.1)	
2	<b>Нийт зардал</b>	сая.төг	1,444.7	1,056.3	4,996.0	(4,996.0)	
	Үүнээс:Үйл ажиллагааны зардал	сая.төг	1,402.0	1,011.5	490.0	(490.0)	
	Үүнээс:Санхүүгийн зардал	сая.төг			4,293.5	(4,293.5)	
	Үндсэн хөрөнгийн элэгдлийн зардал	сая.төг	42.7	44.8	44.8	0	100.0
3	Татварын өмнөх ашиг, алдагдал	сая.төг	(42.7)	(44.8)	(41.5)	(3.3)	92.6
4	Татварын дараах ашиг (алдагдал)	сая.төг	(42.7)	(44.8)	(41.5)	( 3.3 )	92.6
5	Нийт өглөг	сая.төг	54,311.7	69,308.0	60,086.4	(9,221.6)	86.6
	Урт хугацаат өр төлбөр	сая.төг	54,159.2	69,012.0	59,986.1	(9,025.9)	86.9
	Богино хугацаат өр төлбөр	сая.төг	152.5	296.0	296.0	0	100
6	Нийт ажиллагсдын тоо	тоо	3	7	7	0	100
7	Нийт цалингийн сан	сая.төг	76.3	282.6	265.2	(17.4)	93.8
8	Их засвар,ТЗБАХ, Хөрөнгө оруулалт	сая.төг		33.9	33.9	0	100.0

### 3. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Аудитаар нийт 15.6 сая төгрөгийн зөрчил илэрснээс, 2.6 сая төгрөгийн төлбөрийн акт тогтоож, 12.9 сая төгрөгийн 2 зөвлөмж өгсөн.

#### Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Санхүүгийн тайланд үндсэн хөрөнгийн дуусаагүй барилга дансны үлдэгдлийг тус дансны дэлгэрэнгүй бүртгэлийн үлдэгдлээс 9,700.0 мянган төгрөгөөр дутуу тайлагнасан байна.	1	9,700.0					1	9,700.0				
Өөрийн өмчлөлийн тавилга, эд хогшлыг байгууллагад түрээсэлсний орлого, зардлыг төлөвлөж, батлуулахгүйгээр тус орлогыг төвлөрүүлж, үйл ажиллагаандаа зарцуулсан байна.	1	3,250.4					1	3,250.4				
Оффис болон гарашийн барилгын засварын ажлыг гүйцэтгэх ажлын Электроплас ХХК-тай байгуулсан гэрээний дагуу гүйцэтгэлийн эцсийн санхүүжилтийг олгохдоо захиалагч байгууллагад үлдэх ёстой захиалагчийн хяналтын зардал болон магадалшгүй ажлын төсөвт өртгийн дүнг илүү шилжүүлсэн.	1	2,643.0	1	2,643.0								
<b>Дүн</b>	<b>3</b>	<b>15,593.4</b>	<b>1</b>	<b>2,643.0</b>			<b>2</b>	<b>12,950.4</b>				

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитаар зөрчлийг давтан гаргахгүй байх 937.5 сая төгрөгийн 2 албан шаардлага өгсөн.

**Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс			
			Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
<b>Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил</b>						
Эгийн голын усан цахилгаан станц ТӨХХК нь 2023 оны тайлант жилд нийт 28 төрлийн 167 мэдээг шилэн дансны цахим хуудсанд ил тод байршуулснаас цалингийн зардлаас бусад 5.0 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогын 937,522.15 мянган төгрөгийн 6 гүйлгээг хугацаа хоцроож байршуулсан байна. Өмнөх оны аудитаар албан шаардлага өгснийг хэрэгжүүлээгүй, зөрчлийг давтан гаргасан байна.	1	937,522.2	1	937,522.2		
<b>Дүн</b>	1	937,522.2	1	937,522.2		
<b>Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил</b>						
Эгийн голын усан цахилгаан станц ТӨХХК 2023 оны жилийн эцсийн санхүүгийн тайланг хуулийн хугацаанаас хоцроож, 2024 оны 02 дугаар сарын 26-ны өдрийн 01/19 дүгээр албан бичгээр аудитын байгууллагад хүргүүлсэн.	1		1			
<b>Дүн</b>	1		1			
<b>Нийт дүн</b>	2	937,522.2	2	937,522.2		

/мянган төгрөгөөр/